

МОНГОЛ УЛСЫН ИХ СУРГУУЛЬ

ЭРДЭМ ШИНЖИЛГЭЭНИЙ БИЧИГ

№ 15/417

ШУС, НУС

2014

МОНГОЛ ТУУРГАТАН ОРНУУДЫН ТЕЛЕВИЗҮҮДИЙН ҮҮСЭЛ, ХӨГЖЛИЙН ӨНӨӨГИЙН БАЙДЛЫН ТУХАЙ ТОЙМ СУДАЛГАА

Г.Мэндхүү*

* МУИС-ийн Шинжлэх ухааны сургуулийн Нийгмийн ухааны салбарын Сэтгүүл зүй, олон нийтийн харилцааны тэнхимийн багш, доктор (Ph.D)

Түлхүүр үг: Халимагийн телевиз, Буриадын телевиз, Тувагийн телевиз, Өвөр Монголын “Одон” телевиз

Нийгэм, оюун санааны амьдралд телевиз ямар нөлөө үзүүлж байгааг эрдэмтэд олон талаас нь шинжин судалж ирсэн. ОНМХ нь зөвхөн тухайн цаг үеийн тулгамдсан асуудлыг ард түмэнд мэдээллэх, сонордуулах хэрэгсэл төдий бус тухайн улс үндэстний оюун санааны амьдралын “толь” нь болж байдаг. Судлаач Ю. Эрдэнэтuyaа “телевизийн хөтөлбөрийг нэгэн өрх гэр бүлийн амьдралтай зүйрлүүлэн авч үзэх юм бол тухайн гэр бүлийн гишүүдийн соёл, хүмүүжил, сонирхол, хөдөлмөр, боловсрол, эрүүл мэнд, амралт, чөлөөт цаг, идэвх оролцоо гээд бүх л талыг хамарсан өргөн хүрээтэй цогц бодлого явуулахтай адил юм” хэмээн дүгнэсэн байдаг¹. Монгол Улсад 1967 онд телевиз байгуулагдсан нь манай орны нийгэм, соёлын хөгжилд жинтэй хувь нэмэр оруулсан нь маргашгүй үнэн юм.

Өнөөдөр манай дэлхий дээр монгол угсааны 6-10 сая хүртэлх хүн амьдарч байгаа гэсэн тоо баримт байдаг. Гэвч

эх сурвалж бүрд энэ тоог харилцан адилгүй дурдсан байdag. Дэлхийн өнцөг булан бүрд аж төрөн сууж байгаа Монгол түүргатан орнуудад телевиз хэзээ байгуулагдаж байсан талаар тодорхой эх сурвалжуудад тулгуурлан судалж, хуримтлуулсан мэдээллээ хуваалцахыг хичээв.

Халимагийн телевиз. ОХУ-ын бүрэлдэхүүнд багтдаг Бүгд Найрамдах Халимаг Улсын нийслэл Элстэй (Элиста) хотод 1967 онд 100 кв. метр талбай бүхий студитэй, 165 метрийн өндөр цамхагтай телевизийн төв ашиглалтанд оржээ. Үг телевизийн төв нь ЗХУ-ын төв телевизийн нэвтрүүлгийг дахин дамжуулах, мөн Халимагийн үндэсний телевизийн нэвтрүүлгийг явуулах зориулалттай байв. 1967 оны 11-р сарын 5-нд Халимагийн телевиз анхны туршилтын нэвтрүүлгээ хийсэн байна. Энэ өдөр Октябрыйн хувьсгалын 50 жилийн ойд зориулсан хөтөлбөр үзүүлжээ. Хоёр өдрийн дараа буюу 1967 оны 11-р сарын 7-нд Халимагийн телевиз тогтмол нэвтрүүлгээ цацаж эхэлсэн байна. Дамжуулагч станцийн хүчин чадал муу байсан учраас телевизийн төвөөс 25 км-ийн тойрог

хүрээнд нэвтрүүлэг үзэх боломжтой байжээ.

Халимагийн Бүгд Найрамдах Улсын Сайд нарын Зөвлөлийн дэргэдэх Радио телевизийн улсын хорооны даргаар Сергей Санджиевич Васькин томилогджээ. Тэрээр энэ албан тушаалыг 17 жил хашсан юм. Халимагт телевиз үсгэн байгуулахаас эхлээд хөгжүүлэхэд Сергей Санджиевич Васькин үнэлж баршгүй хувь нэмэр оруулжээ. 2013 оны 11-р сарын 21-нд дэлхийн телевизийн өдөр Сергей Санджиевич Васькин 93 насандаа хорвоогийн мөнх бусыг үзүүлжээ. Энэ тухай “Известия Калмыкии” сонинд бичих байв.

Өнөөгийн байдлаар Халимагт Оросын Первый канал, Россия, НТВ зэрэг сувгуудын хөтөлбөрийг үзэж болно. Мөн халимаг хэлээр нэвтрүүлэг үзүүлдэг нэг суваг ажиллаж байна. Гэхдээ Халимагийн телевизийн нэвтрүүлгийн сүлжээнд нь төрөлх хэлзэрээ нэвтрүүлэг тун бага хувийг эзэлж байна. Халимагийн телевиз “Вести-Калмыкия” мэдээллийн хөтөлбөр орос хэлээр, “Обсудим вместе” ярилцлага, “Детали”, “За горизонтом времен”, “На городской волне” зэрэг нэвтрүүлгийг орос хэлээр, мөн төрөлх хэлзэрээ “Өрүнө ńарц”, “Йорэлин дун” зэрэг нэвтрүүлгийг бэлтгэж байна. Халимагийн телевизийн

Буриадын телевиз. Буриадын Улаан-Үд хотод 1961 онд телевизийн төв баригдээ. 1967 оноос Буриадын телевизийн сувгаар ЗХУ-ын төв телевизийн нэвтрүүлгийг “Орбит” станцийн тусламжтайгаар дахин дамжуулдаг болсон байна.

Буриадын телевизийн салбарын хөгжлийн талаар судалгаа шинжилгээний ажил бичсэн судлаач С. В. Пономаренко “С. В. Хрущев төрийн эрх

баржь байх үед Буриадад телевизийн тогтмол нэвтрүүлэг явуулж төлөвшүүгээ хүртэл буюу Буриадын телевизийн дэвшигийг сайжруулж, нэвтрүүлж, төрөл зүйл төлөвшөн үе, 1985-аад 1991 оны өөрчлөн байгуулалтын үеийн Буриадын телевиз” гэсэн гурван үеийн хуваажээ².

Буриадад телевиз байгуулах үеийн явц нь тухайн үеийн Оросын удирдагчдын боловсруулсаар хөтөлбөрийн дагуу өрнөжээ. 1960-аад оны үед Орос улсад орон нутгийн телевиз байгуулах төсөл хэрэгжсэн юм. Буриадын телевизийн анхны ажилчид уран бүтээлчид нь хөрш зэрэглэдээ Иркутск, Новосибирск, Чита зэрэг бүх нутгаас ирсэн байна. Телевизийн байгуулгдаад удаагүй байсан анхны жилүүдэд нэг албан хаагч давхар хэдэн өөр мэргэжилтэний Үүргийн гүйцэтгэдэг байв. Жишээ нь зураглах нийтийн төслийн чадварт суралцах нэвтрүүлэг найруулж, эвлүүлэг хийдэг байжээ. Телевизэд ажиллах сонирхолтой хүн олон байсан ч хатуу шалгуур тавьдаг учраас тэнцэхүү хасагдах байдал 1960-аад онд түгээмэл байв. Тэгвэл 1980-аад оны үед телевизийн салбарын мэргэжилтнүүд цалин хөлсний байдлаас болж ажлаа орхиж, өөр бус нутагт ру хөдөлмөр эрхлэх байдал түгээмэл байв. Энэ нь Буриадын телевизийн хүний нөөцөд сөргөөр нөлөөлжээ. Тэгвэл 1990 оноос хойш телевизийн салбарт олон шинэ мэргэжилтнүүд орж ирсэн байна.

Нэвтрүүлэг, уран бүтээлийн агуулга хэлбэрт нь хатуу хяналт тогтоосон байлаа. Буриадын хэвлэлийг хянах газар цензур тогтоох гэж ажлыг гүйцэтгэдэг байв. Өөрчлөн байгуулалт эхлэх хүртэл Буриадын телевиз суртал

уухуултын зэвсэг болсон байлаа. 1967 оноос “Орбит” станцаар Оросын төв телевизийн нэвтрүүлэг үзүүлдэг болсноор Буриадын телевизийн өөрийн уран бүтээлийн зэлэх хувь хэмжээ буурч, төрөлх буриад хэлээр нэвтрүүлэг бэлтгэх нь ч багасжээ.

1985 оноос хойш Буриадын телевизийн уран бүтээлчдэд уран бүтээлийн эрх чөлөө аажмаар бүрэлдэж эхэлжээ. 1990-ээд оны үесэд тэд асуудал дэвшүүлсэн нийтлэл нэвтрүүлэг бэлтгэх нь эрс нэмэгдэжээ.

Өнөөдрийн байдлаар

Буриадад “Тивиком”, “Ариг Ус”, “Бурятия” гэсэн гурван телевизийн үйл ажиллагаа явуулж байна. “Бурятия” телевизийн ОХУ-ын төрийн мэдлийн “Россия” телевизийн салбар юм. Россия-1 сувгийн нэвтрүүлгийг дахин дамжуулахаас гадна тодорхой цагуудад Буриадын Улаан-Үд хотын студээс мэдээ нэвтрүүлдэг.

Буриадын “Ариг Ус” телевизийн 1992 онд байгуулагджээ. Анхны эфирээ 1992 оны 6-р сарын 1-нд өглөө 6:00 цагт эхэлжээ. Тухайн үед дуу хөгжмийн клип, VHS хальсанд дээр бичсэн видео кино, мэдээ үзүүлсэн байна. Орос улсад үүссэн улс төрийн эзэлтэй нөхцөл байдлаас болж 1993 оны 8-р сард тус телевизийн үйл ажиллагааг зогсоосон байна. 1994 оноос “Ариг Ус” телевизийн дахин эфирээ нээсэн байна. Одоо тус телевизийн үеийн эзэлтэй хамгийн олон үзэгчтэй, нэр хүндтэй болжээ. “Ариг Ус” телевизийн “Цагаан сарын одод” олон улсын наадам, “Мунгэн сэргэ” ардын дууны уралдаан

зохион байгуулдаг. “Ариг Ус-24” кабелийн сувагттай.

Буриадын телевизийн үүсэл, хөгжлийн түүх сэдвээр докторын түвшинд судалгааны ажлыг Буриадын Улсын Их Сургуулийн аспирант Пономаренко Сергей Владимирович 2012 онд бичиж эрдмийн зэрэг хамгаалсан байна. Буриадын телевизийн түүхийн талаар бичсэн анхны ажил нь энэ юм. Чухал баримтуудыг анх удаа судалгааны эргэлтэнд оруулсан ажээ.

2012 оны 6-р сарын 30-аас DVB-T2 стандартаар Буриадад тоон технологи ашиглан телевизийн нэвтрүүлэг дамжуулж эхэлсэн. Тоон технологид шилжихийн өмнө Буриадын 16 бус нутагт өргөн нэвтрүүлгийн тоон технологийн 60 дэд станц байгуулжээ.

Өвөр Монголын телевиз. Өвөр Монголын “Одон” телевизийн Хөх хотод байрладаг. Өвөр Монголд 1976 онд телевизийн студи байгуулагджээ. 1980-аад оноос “Одон” телевизийн биээ даасан суваг болжээ. 2008 оноос “Одон” телевизийн 24 цагийн эфиртэй болсон байна. “Одон” телевизийн 1600 гаруй албан хаагчдын 350 нь монгол хэлээр нэвтрүүлэг сувагт ажилладаг. “Одон” телевизийн нийт албан хаагчдын 51,6 хувь нь монгол, манж, звеники, дагур зэрэг үндэстний цөнхүүд бурдүүлдэг. “Одон” телевизийн монгол, хятад хэлээр нэвтрүүлэг дамжуулдагаас гадна кино, олон ангит жүжиг үзүүлдэг тусгай сувагттай. “Одон” телевизийн сувгуудыг Өвөр Монголоос гадна БНХАУ-ын өөр 8 бус нутагт хиймэл дагуулаар дамжуулдаг. Ер нь

издэж буйгаасаа дамжуулдагаас гадна кино, олон ангит жүжиг үзүүлдэг тусгай сувагттай. “Одон” телевизийн сувгуудыг Өвөр Монголоос гадна БНХАУ-ын өөр 8 бус нутагт хиймэл дагуулаар дамжуулдаг. Ер нь

Өвөр Монголд өөр 8 телесуваг бий. Өвөр Монголын телевизийн санхүүжилтийн 60 хувийг Бэзжингээс үлдснийг нь орон нутгийн төсвээс бурдуулдэг. Өвөр Монголын "Одон" телевиз кинонд дуу оруулахдаа тусгай дуу чимээ үүсгэдэг мэргэжлийн багажиллуулдаг. Мөн тус телевиз түүхэн сэдэвт олон ангит кино бүтээж тодорхой туршлага хуримтлуулжээ.

Тувагийн телевиз. 1966 оны 6-р сарын 11-нд Тувагийн телевиз анхны нэвтрүүлгээ дамжуулжээ. ЗХУ-ын Бүгд найрамдах Тува улсад телевиз байгуулахдаа хөрш зэрэлдээ Бийск хотын телевизийн уран бүтээлчдийн туршлагыг дэлгэрүүлжээ. 1966 онд Тувагийн телевиз зөвхөн өөрсдийн бэлтгэсэн нэвтрүүлгээ цөөн цагаар үзүүлдэг байв. Харин 1969 оноос "Орбита" станц ашиглалтанд орж ЗХУ-ын төв телевизийн нэвтрүүлгийг тувачууд үздэг болжээ. Тухайн үед дүрсэн өгүүлээмж (сюжет)-ийг 16 миллин хар цагаан хальсан дээр бичдэг байв. 1980-аад оны сүүлээр S-VHS, SP зэрэг соронзон хальс ашигладаг болов.

1975 оноос хойш энэ салбарт ажилласан Лидия Донгак "Тувинская правда" сонинд хэвлүүлсэн дурсамжиндаа телевизийн хүний нөөцийг бурдуулэхэд тухайн үедээ онцгой анхаарч байсан цохон тэмдэглэсэн байна. Телевизийн ажилтнуудыг сургаахаа бага албан тушаалаас эхлүүлж, тодорхой ажлын туршлага хуримтлуулсан хойно хариулагатай ажилд томилдог туршлага нэвтрүүлжээ.

1980-аад оны үед Тувагийн телевиз эрчимтэй хөгжлийн үедээ оржээ. Энэ үед телевизийн тоног төхөөрөмжийг шинчилсэн байна. Тухайн үед шуурхай хурлын үеэр телевизийн найруулагч видеокамертай ажиллаж, эвлүүлэг хийж, хэрэгтэй хөгжмийг сонгож,

шаардлагатай бол дууны найруулажийн пультний ард суудаг байх ёстой хэмээн ярж байжээ. Тувагийн телевизийн соёлыг хойч үедээ өвлүүлэхэд чухал үүрэг гүйцэтгэсэн юм. Гэвч орон нутгийн хэмжээнд нэвтрүүлэг дамжуулдаг тул нэвтрүүлгийн сэдвийн хүрээ нь явцуу байсан юм. Тувагийн түүхэнд анх удаа 1990 оны 5-р сарын 12-нд зургаан цаг үргэлжилсэн шууд нэвтрүүлэг – телемарафон зохион байгуулжээ.

Сүүлийн үед Тувагийн телевизийд шинэ технологи нэвтрэч байна. 2012 оны 3-р сараас Тувад телевизийн нэвтрүүлгийг тоон форматаар хүлээн авч эхэлжээ. 2012 оны 6-р сарын 29-ний өдрөөс DVB-T2 тоон системийн стандарт хэрэглэдэг болжээ. Тоон мультиплексийн багцал Первый канал, «Россия-1», НТВ, 5 канал, «Россия-2», «Россия-Культура», «Россия-24», «Карусель», 3 радио суваг багтжээ. Одоо Тувагийн нийт оршин суугчдийн 91,2 хувь нь тоон технологиор телевизийн нэвтрүүлэг хүлээн авч үзэж байна. Телевизийн нэвтрүүлгийг тоон технологиор дамжуулдаг болсон тул хэрэглэгчдэд мэдээлэл өгөх тусгай төв Тувад 2012 оны 9-р сарын 18-нд нээгдсэн байна.

2011 оны 8-р сарын 8-нд Тувагийн үндэсний музейд тус бүгд найрамдах улсад радио байгуулагдсаны 75. телевизийн 45 жилийн ойд зориулсан үзэсгэлэн зохион байгуулагджээ. Ул үзэсгэлэнд Тувагийн радио, телевизийн сан хөмрөгт хадгалагдаж байгаа архивийн баримт бичиг, гэрэл зураг, дээр үед ашиглаж байсан тоног төхөөрөмжийг дэлгэн тавьсан байна. 2011 онд Тувагийн радиогийн 75. телевизийн 45 жилийн ойн баярын үеэр тус орны радио, төлөвийн хөгжлийн тухай ном гаргах Тувагийн

тэргүүн Шолбан Кара-оол мэдэгдэж байжээ.

Дээр өгүүлсэн баримтуудыг шинжин үзвээс дараах нийтлэг шинжүүд байгааг цохон тэмдэглээ.

Нэгдүгээрт, Монгол түүргатан орнуудад телевизийн төв байгуулж, төлө нэвтрүүлэг дамжуулах анхны оролдлого XX зууны 60-70-аад онд өрнөжээ. ЗХУ (хуучин нэрээр)-ын тухайн үеийн эрх баригчдын хэрэгжүүлсэн "Орон нутгийн телевизийн сүлжээ бий болгох" хөтөлбөрийн хүрээнд Буриад, Тува, Халимагт телевизийн байгуулагдсан байна. Харин БНХАУ-д соёлын хувьсгал дууссаны дараа ӨМӨЗО-нд телевизийн нээгдсэн байна. Дашрамд дурдахад соёлын хувьсгалын жилүүдэд БНХАУ-д радио, телевизийн салбар бүхэлдээ уналтанд орж, олон тооны радиостанц, телевизийн студи хаагдаж байсан юм. Харин соёлын хувьсгалын дараа нөхцөл байдал дээрдсэн байдал.

Хоёрдугаарт, Буриад, Тува, Халимагт телевизийн байгуулагдаж үйл ажиллагаагаа эхэлсэн анхны жилүүдэд зэрэглээ бүс нутгаас мэргэжилтнүүдийг томилон ажиллуулж байсан нийтлэг дүр зураг ажиглагдаж байна. Улмаар телевизийн салбарын мэргэжилтнүүдийг бэлтгэх, хүний нөөцийн асуудал үе шаттай арга хэмжээ авснаар байдал тогтвортожээ. Гэвч орон нутгийн телевизийд ажилласан хүний нөөцийн асуудал одоо ч бүрэн төгс шийдэгдээгүй байна.

Гуравдугаарт, Монгол түүргатан орнуудын телевизийн нэвтрүүлгийн сүлжээ нь цомхон, өөрийн үйлдвэрлэж байгаа нэвтрүүлгийн нэр төрөл, давтамж маш бага байна. Энэ нь үзэгчдийн хүрээ багаас гадна тухайн телевизийд ажиллаж байгаа уран бүтээлчдийн ур чадвар, телевизийн

хөрөнгө төсөв, тоног төхөөрөмжийн хүчин чадал зэрэг олон хүчин зүйлээс шалтгаалж байгааг тэмдэглэх нь зүйтэй юм. Ер нь орон нутагт телевизийн байгуулахдаа улсынхаа төв телевизийн нэвтрүүлгийг дахин дамжуулах станц бий болгох зорилготой байжээ.

Дэлхийн дээр амьдарч байгаа Монгол үндэстний гол цөм, оюун санааны хөгжлийн төв нь Монгол Улс юм. МҮОНТВ болон бусад арилжааны телевизүүд Буриад, Тува, Халимаг, ӨМӨЗО-ны телевизүүдэд монгол хэлээр бэлтгэсэн дуу хөгжмийн нэвтрүүлэг, уран сайхны болон олон ангит кино зэргийг нийлүүлэх боломж бий. Ингэснээр монгол түүргатан орнуудад Монгол Улсыг сурталчлах, хилийн цаана аж төрж байгаа монгол угсаатнуудад мэдээллийн нэгдмэл орон зай үүсгэх зэрэг чухал ач холбогдолтой юм.

Ишлэл

¹ Эрдэнэтуюя Ю. 2010. Монгол телевизийн 1977-1990 оны нийтэлийн бодлогод хийсэн тойм судалгаа. // "Сэтгүүл зүй" МУИС-ийн ЭШБ. №11/337, 137-146 дахь тал.

² Пономаренко С. В. 2011. становление и развитие материально-технической базы телевидение в Бурятии (1960-1970) // Вестник Бурятского Государственного Университета. Улан-Удэ.

Ашигласан бүтээлийн жагсаалт

1. Эрдэнэтуюя Ю. 2010. Монгол телевизийн 1977-1990 оны нийтэлийн бодлогод хийсэн тойм судалгаа. // "Сэтгүүл зүй" МУИС-ийн ЭШБ. №11/337.

2. Пономаренко С. В. 2011. Становление и развитие материально-технической базы телевидение в Бурятии (1960-1970) // Вестник Бурятского Государственного Университета. Улан-Удэ.

3. "Известия Калмыкий" сонин [www.elista.org](http://elista.org)

4. Тува-онлайн цахим сонин www.tuva-online.ru
5. "Информполис" цахим сонин <http://www.infpol.ru/>

Резюме

В статьи автором рассматривается возникновение и процесс становления

телестанций в монголоязычных странах. Даётся подробное описание и характеристика некоторых телепрограмм Тувы, Калмыкии, Бурятии и Внутренней Монголии. А также рассматривает возможности сотрудничества телевидения Монголии с некоторыми региональными телестанциями соседних стран.